



**МОНГОЛ УЛСЫН  
БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ,  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Нэгдсэн Үндэстний гудамж 5/2, Засгийн газрын II байр,  
Утас: 26 28 30, 26 61 71, Факс: (976-11) 32 09 43, 26 62 86,  
E-mail: contact@mne.gov.mn, http://www.mne.mn

2015. 09. 28 № 01/5828

танай 2015. 09. 31 -ны № хэс/1676 -т

**МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН  
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН  
ДАРГА С.БАЯРЦОГТ ТАНАА**

Олборлох үйлдвэрийн ил тод байдлын санаачилгын стандартын дагуу баталгаажуулалтад бэлтгэх ажлын төлөвлөгөөний 1.3-д заасан мэдээллийг гарган хүргүүллээ.

Хүлээн авч танилцана уу.

Хавсралт /2/ хуудастай.



Н.БАТЦЭРЭГ

012081

## ТАНИЛЦУУЛГА

Нэг. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн хэрэгжилт

УИХ-ын 2015 оны 2 дугаар сарын 18-ны хуралдаанаар Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийг баталсан.

А/Засгийн газрын 2015 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 120 дугаар тогтоолоор “Гол, мөрний урсац бүрэлдэх эхийн бүсэд олгосон тусгай зөвшөөрлийг цуцлах, усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж эхэлсэн, тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээлт хийлгэх журам”-ыг баталсан. Уг журмаар Гол, мөрний урсац бүрэлдэх эхийн бүсэд олгосон тусгай зөвшөөрлийг цуцлах, усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж эхэлсэн, тусгай зөвшөөрөл бүхий талбайд (цаашид хориглосон талбай гэх) холбогдох арга хэмжээ авах, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт хийлгэх үйл ажиллагааг зохицуулахаар болсон.

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2015 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн А-185 тоот тушаалаар Усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүсийн хилийн заагийг тусгай зөвшөөрөл бүрээр тогтоох, хилийн заагийг зөвшөөрөөгүй гомдлыг шийдвэрлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүн, Усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүсийн хилийг тогтоох ажлын удирдамжийг баталсан. Усан сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсийг Гадаргын усны сүлжээний тоон зураг, усны тооллогын мэдээ, 1:100000 масштабын байр зүйн зургийг үндэслэн гадаргын усны сүлжээний зургийг дахин тодруулах, ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүрээр давхцалыг гаргах замаар гүйцэтгэх гүйцэтгэх болсон.

Б/БОНХАЖЯ-аас нийт 75 аж ахуйн нэгжийн ирүүлсэн гомдол ирүүлсний 80 гаруй хувийг газар дээр нь танилцсан бөгөөд үүний 27 нь урсац бүрдэх эх, 35 нь усан сан бүхий газрын хамгаалалтын бүс, 10 нь ойн сан бүхий газрын хил заагтай холбоотой байсан байна. “Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль”-ийн хэрэгжсэн 5 жилд тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн ашиглалтын ажил зогссон хэдий ч хууль бусаар ашигт малтмал олборлогчид их хэмжээгээр газрыг сүйтгэдэг, эвдэгдсэн газрыг нөхөн сэргээлгүй

орхидог, орон нутгийн болон улсын төсөвт орлого оруулдаггүй зэрэг олон сөрөг үзэгдэл бий болсон нь тогтоогдсон.

#### **В/.Хориглосон бүс тогтоосон тухай**

Эдийн засгийн эрчимжүүлэх, алт олборлолтыг нэмэгдүүлэх, нөхөн сэргээлт хийх ажлыг эхлүүлэх зорилгоор Засгийн газрын 2011 оны 174, 2012 оны 194 дүгээр тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулан 2015 оны 7 дугаар сарын 7-ны өдөр 289, 7 дугаар сарын 20 нд 302 дугаар тогтоолоор урсац бүрэлдэх эх, ойн сан бүхий газрын хамгаалалтын бүсийн зарим хэсэгт өөрчлөлт оруулж, усны сан бүхий газрын эргээс 50 метрт онцгой, 200 метрт энгийн хамгаалалтын бүс тогтоохоор шийдвэрлэсэн.

Засгийн газрын 2015 оны 289 дүгээр тогтоолын хавсралтаар Гол мөрний урсац бүрэлдэх эхээс 13 ш, ойн сан бүхий газрын хамгаалалтын бүсээс 15 ш тусгай зөвшөөрлүүд тус тус чөлөөлөгдсөн байна. Засгийн газрын 2015 оны 302 дугаар тогтоолын хавсралтаар Гол мөрний урсац бүрэлдэх эхээс 6 ш, ойн сан бүхий газрын хамгаалалтын бүсээс 5 ш, усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсээс 1 ш ашигт малтмалын тусгай зөвшөөрөл чөлөөлөгдсөн.

Цаашид Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд:

а/ “Гол, мөрний урсац бүрэлдэх эхийн бүсэд олгосон тусгай зөвшөөрлийг цуцлах, усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж эхэлсэн, тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээлт хийлгэх журам”-ын хэрэгжилтийг аймаг, сумдад газар дээр нь шалгах, холбогдох арга хэмжээг авах.

б/.Засгийн газрын 2015 оны 289 дүгээр тогтоолын 1-д заасны дагуу энэ оны 10 дугаар сарын 1-ний дотор Усны сан бүхий газрын эргээс 50 метрт онцгой, 200 метрт энгийн хамгаалалтын бүс тогтоох, тэмдэгжүүлэх ажлыг гүйцэтгэх.

в/.Засгийн газрын 2015 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 120 дугаар тогтоолоор баталсан “Гол, мөрний урсац бүрэлдэх эхийн бүсэд олгосон тусгай зөвшөөрлийг цуцлах, усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж эхэлсэн, тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээлт хийлгэх журам”-ын 3.1-д заасны дагуу гэрээ байгуулах, 4.8-д заасны дагуу нөхөн сэргээлтийн ажлыг хүлээн авах.

#### **Хоёр. Газрын хэвлийн эвдрэл, нөхөн сэргээлтийн тухай.**

2015 оны 1дүгээр сарын 06-ны байдлаар ашигт малтмалын 2736 тусгай зөвшөөрөл 11.0 сая га талбайд олгогдсон байгаа нь нийт нутаг дэвсгэрийн 7.0 хувийг эзэлж байна. Үүнээс ашиглалтын 1391 тусгай зөвшөөрөл бүхий 1079.9 мян га, хайгуулын 1345 тусгай зөвшөөрөл бүхий 9.9 сая га талбайг эзэлнэ.

2013 оны эцсийн байдлаар уул уурхайн үйлдвэрлэлийн зориулалтаар нийт 24636.8 га газар эвдэгдсэнээс 10263.1 га-д буюу 41.65 хувьд техникийн нөхөн

сэргээлт, 6781.5 га-д буюу 27,5 хувьд биологийн нөхөн сэргээлт хийжээ. Энэхүү танилцууллагад уул уурхайн зориулалтаар эвдэгдсэн газар, нөхөн сэргээлтийн судалгаа (хүснэгт 1), (график 1)

### Хүснэгт:1

Уул уурхайн зориулалтаар эвдэгдсэн газар, нөхөн сэргээлт, 2006-2013




График:1. 2013 оны байдлаар уулын ажилд хамрагдсан газар, нөхөн сэргээсэн газар

*Тайлбар: Ашигт малтмалын тухай хуулийн 48.1.2-д заасны дагуу дүн мэдээ жил бүрийн 2 дугаар сарын 15-ны өдрөөс хойш нэгтгэгдэх боломжтой болдог тул 2013 оны мэдээг тайлагнаж байна. Эх үүсвэр: БОНХАЖЯ-ны ХБОБНУГ, УУЯ-ны АМГ-ын Уул уурхайн хэлтэс, Нүүрсний хэлтэст ирүүлсэн тайлан*

Цаашид нөхөн сэргээлтийг салбарын онцлогыг харгалзан төлөвлөх, нөхөн сэргээгдсэн газрыг хүлээн авах эрх зүйн орчинг боловсронгуй болгох, мэргэжлийн байгууллагуудыг бэхжүүлэх, нөхөн сэргээлтийн барьцааны хөрөнгийг тооцох арга аргачлалыг шинэчлэх, зах зээлийн харилцаанд шилжүүлэх судалгаа хийж авах арга хэмжээг тодорхойлон хэрэгжүүлэх шаардлагатай байна.

### Гурав. Бичил уурхайн асуудлаар

Засгийн Газрын 2010 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн 308 дугаар тогтоолоор “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам” батлагдсанаас хойш 2015 оны 05 дугаар сарын 08-ний байдлаар нийт 12 аймгийн 27 суманд 72 талбай буюу нийт 976,13 га талбайг хамарч байна. Дүгнэлт гарсан 72 талбайгаас 18 талбайг “Ашигт малтмалын тухай” хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу бичил уурхайн зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авахаар Кадастрын зураг зүйн нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн байна.

Ашигт малтмалын газраас 2012 онд 10 аймгийн 25 талбай буюу 856,55 га, 2013 онд 1 аймгийн 1 сумын 3 талбай буюу 15,87 га, 2014 онд 6 аймгийн 6 суманд 10 талбай буюу 56,21 га, 2015 оны эхний улирлын байдлаар 1 аймгийн 1 суманд 7 талбай буюу 41,99 га газарт бичил уурхайгаар ашигт малтмал олборлох боломжтой дүгнэлт гараад байна.

Үүнээс хамгийн их дүгнэлт гарсан Төв аймгийн Заамар сум бөгөөд нийт 10 талбай буюу 59,84 га газарт бичил уурхайгаар ашигт малтмал олборлох боломжтой гэж дүгнэлт гаргасан байна.

Энэхүү танилцуулгад Бичил уурхайгаар ашиглаж буй талбайн мэдээлэл, Бичил уурхайгаар ашиглах боломжтой гэж гарсан талбайн мэдээлэл, Хууль бусаар олборлолт явуулж байгаа газрын мэдээлэл, Бичил уурхайчдын хийсэн нөхөн сэргээлтийн мэдээ зэргийг хавсаргав.

Хүснэгт: 2.

Бичил уурхайгаар ашиглаж буй талбайн мэдээлэл

Аймаг	Сум	Талбайн нэр	Талбайн хэмжээ /га/ ашигт малтмалын төрөл/	Ажиллаж байгаа эсэх	Ажиллаж буй хүний тоо
1	2	3	4	5	6
1.Дорноговь	Айраг	Самартайн цагаан дэл	4.89 жонш	ажиллаж байсан	100 гаруй
	Иххэт	Цагаан шороот-1	13.99 жонш	ажиллаж байсан	50
		Цагаан шороот-2	4.55 жонш	ажиллаж байсан	50
		Цагаан элгэн	20.06 жонш	ажиллаж байсан	20
2.Дундговь	Баянжаргал ан	Сүүл-Өндөр 1-р талбай	2.48 жонш	ажиллаагүй	
		Сүүл-Өндөр 2-р талбай	4.93 жонш	ажиллаагүй	
		Хөх дэл-1	97.43 жонш	ажиллаагүй	
		Хөх дэл-2	5.0 жонш	ажиллаагүй	
		Хөх дэл-3	5.0 жонш	ажиллаагүй	
		Нүдэн	7.34 жонш	ажиллаагүй	
	Гурвансайхан	Их газрын чулуу	17.36 жонш	ажиллаагүй	
	Өлзийт	Ембүү толгой	38.52 жонш	Суманд хүлээлгэн өгсөн.	
	Хулд	Түймэрт цагаан	117.58 жонш	ажиллаж байгаа	15 нөхөрлөл 300 гаруй

	Дэлгэрханга й	Шарвагийн усны хяр	49.74 жонш	ажиллаагүй	
	Луус	Хадат улаан орчим	47.93 жонш	Ажиллаж байсан	200 гаруй
3.Хэнтий	Батноров	Ухаа овоот	1.9 жонш	Ажиллаж байсан	15
		Жавхлант	1.08 жонш	Ажиллаж байсан	40
		Өндөр ухаагийн хэжүү	1.5 4жонш	Ажиллаж байсан	30
		Түмэнгийн ар	3.66 жонш	Ажиллаж байсан	50
		Салхитын цагаан толгой- 1	1.92 жонш	Ажиллаж байсан	20
		Чимэдийн хөндлөн	5.87 жонш	ажиллаагүй	
		Салхитын цагаан толгой- 2	4.22 жонш	Ажиллаж байсан	20
		Баян-адрага	Хөлийн холбоо-1	6.77 жонш	Ажиллаж байсан
	Хөлийн холбоо-2		5.13 жонш	Ажиллаж байсан	20
	Хөлийн холбоо-3		11.53 жонш	Ажиллаж байсан	20
	Хөлийн холбоо		50.03 жонш	Ажиллаж байсан	20
	Дархан	Чулуутын ам	6.87 жонш	ажиллаагүй	
		16-р хүдрийн биетийн орчим	0.79 жонш	ажиллаагүй	
		Бор-Өндөр зүүн урд	5.57 жонш	Ажиллаж байсан	40
	Хэрлэн	Ихэр	4.67 жонш	ажиллаагүй	
Норовлин	Шалз	44.54 жонш	Ажиллаж байсан	40	
4.Дархан- уул	Шарын гол	Их шарын гол- 1	11.65 алт	ажиллаагүй	
		Цагаан хөтөл	12.59 алт	ажиллаагүй	
		Шар хөндий	5.0 алт	ажиллаагүй	
		Шарын хөндий-1	2.91 алт	ажиллаагүй	
		Шарын хөндий-2	59.09 алт	ажиллаагүй	

5.Өвөрхангай	Нарийн тээл	Дунд түрүүний хавирга	3.62 алт	ажиллаагүй	
		Буйлсан сайр	3.2 алт	ажиллаагүй	
		Хараат ягааны баруун жалга	1.12 алт	ажиллаагүй	
		Хараат ягааны өврийн жалга	10.69 алт	ажиллаагүй	
		Уужим булан	5.21 алт	ажиллаагүй	
6.Булган	Бүрэгхангай	5 дахь талбар	12.49 алт	ажиллаагүй	
		6 дахь талбар	17.99 алт	ажиллаагүй	
7.Төв	Сэргэлэн	Гурван жалга	5.15	ажиллаагүй	
		Баруун баруун урт	29.4 алт	ажиллаагүй	
	Батсүмбэр	Хуучин угаасан овоолго	7.99 алт	ажиллаагүй	
	Эрдэнэ	Уст гозгор	5.01	ажиллаагүй	
8.ОРХОН	Баян-өндөр		6.12	ажиллаагүй	
			5.84	ажиллаагүй	
9.Сэлэнгэ	Мандал	Рашаантын ам	3.08	Ажиллаж байсан	56
		НОЁТ	12.29	ажиллаж байгаа	56
	Сайхан	Бор толгой уул	5 Чулуу	ажиллаагүй	
	Хүдэр		20.79 алт	ажиллаагүй	
10.Архангай	Цэнхэр	Аршанд	6.97	Ажиллаж байсан	100
	Цэцэрлэг	Хатуу ухаа	6.94	Ажиллаж байсан	4
10	25 сум	55 талбай	856.55		

Тайлбар: /2012 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар/

Хүснэгт: 3.

Бичил уурхайгаар ашиглах боломжтой гэж гарсан талбайн мэдээлэл

	Аймаг	Сум	Талбайн нэр	Талбайн хэмжээ/га/	Ашигт малтмалын төрөл
1	ТӨВ	Заамар	Өвөр сайр	4,06 га	алт
			Ганц хайлааст жалга	4,34 га	алт
			Туулын баруун дэнж	10,62 га	алт

			баян гол		
			Баян гол	5,66 га	алт
			Баян гол адаг	1,35 га	алт
			Баян голын адаг	4,71 га	алт
			Баян гол адаг	11,25 га	алт
2	Дундновь	Луус	Шаргал	10,01 га	ЖОНШ
				10,33 га	ЖОНШ
3		2	8 газар	9 талбай 62,33 га	

Тайлбар:2015 оны 5 дугаар сарын 8-ны байдлаар

Хүснэгт: 4.

Хууль бусаар олборлолт явуулж байгаа газрын мэдээлэл

	Аймаг	Сум	Талбайн нэр	АМ-ын төрөл
1	Төв	Заамар	Өлийн даваа	Алт
2	Төв	Заамар	Цагаан чулуут	Алт
3	Өмнөговь	Гурвантэс	Гүн	Улаан чулуу
4	Баянхонгор	Баян-овоо		Алт
5	Баянхонгор	Бөмөгөр		Алт
6	Сэлэнгэ	Ерөө	Бугант тосгон	Алт
7	Сүхбаатар	Сүхбаатар	Цагаандэл	Алт
8	Увс	Өмнөговь		Алт
9	Дорноговь	Дэлгэрэх		Алт
10	Ховд	Цэцэг	Цагаан эрэг	Вольфрам
11	Ховд	Алтай		Вольфрам
12	Ховд	Булган		Алт
13	Говь-Алтай	Дэлгэр	Хүрэнтийн амны Улаан толгой	Алт
14	Төв	Сүмбэр	Баруун тахилгат	Алт
15	Увс	Тариалан		Алт
16	Завхан	Ургамал		Алт
17	Завхан	Дөрвөлжин		Алт
18	Ховд	Дөргөн		Алт
19	Говь-Алтай	Есөнбулаг		Алт
20	Төв	Сүмбэр		Алт

Бичил уурхайчдын хийсэн нөхөн сэргээлтийн мэдээ

Хүснэгт 5

Д/Д	он	Нөхөн сэргээсэн талбайн хэмжээ /га/	Д/Д	он	Нөхөн сэргээсэн талбайн хэмжээ /га/

1	2010	2	4	2013	
2	2011	5	5	2014	
3	2012	56,53		2015	
нийт					85.21

Бичил уурхай эрхлэгдийн эвдэгдсэн газрыг нөхөн сэргээх, нөхөн сэргээсэн газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах, эзэнжүүлэх, бичил уурхайд ажиллагсдыг сургах, мэргэжил эзэмшүүлэх, ажлын байраар хангах зэрэг асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй байна.

Тав. Байгалийн нөөц баялаг ашигласны төлбөрийн орлогын талаар

А. Байгалийн нөөцийн төлбөрийн орлогын бүрдүүлэлт

Төсвийн тухай хуульд заасны дагуу 2013 оноос эхлэн байгалийн нөөц ашигласны төлбөр аймаг, нийслэл, сум, дүүргийн төсөвт 100% төвлөрөх болсон байна /Хүснэгт 1/.

*Хүснэгт 6*  
*Байгалийн нөөц ашиглалтын төлбөрийн орлогын бүрдүүлэлт /мян төгрөгөөр/*

Он	Ойгоос мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр	Ус ашигласны төлбөр	Газрын төлбөр	Байгалийн ургамал ашигласны төлбөр	Агнуурын нөөц ашигласны төлбөр	Нийт төсөвт төвлөрсөн дүн
2008 он	1,507,464	2,811,510	2,352,658	35,773	114,726	6,822,131
2009 он	1,738,802	339,643	2,673,762	38,381	4,593,158	9,383,746
2010 он	219,738	4,716,838	5,653,201	41,489	4,059,351	14,690,617
2011 он	2,278,897	2,796,757	10,370,888	30,383	474,947	15,951,872
2012 он	2,469,251	11,545,958	14,847,599	50,099	239,908	29,152,815
2013 он	2,880,333	39,188,367	6,700,000	33,052	542,929	49,344,681
2014 он	2,942,500	34,354,300	6,500,000	553,400	920,900	45,271,100

2013 онд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого нийт 49.3 тэрбум төгрөг аймаг, нийслэл, сумдын дансанд төвлөрчээ. Үүнээс Байгалийн нөөцийн төлбөрийн тухай хууль, холбогдох журмаар хамгийн багадаа 20-25 тэрбум төгрөгийг байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөсөн болно.

2014 оны урьдчилсан дүнгээр 45.87 тэрбум төгрөг аймаг, нийслэл, сумдын төсөвт төвлөрсөн мэдээлэл байна.

Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн хүрээнд аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, тусгай хамгаалалттай газрын хамгааллын менежментийг сайжруулах чиглэлээр 60 гаруй эрх үүргийг хүлээлгэсэн байна. Аймаг, сумын Засаг дарга нарын эрх үүрэгт 6 төрлийн менежментийн төлөвлөгөөг боловсруулж, үүнтэй холбоотой арга хэмжээг орон нутагт хэрэгжүүлэхийг хуульчилсан. Үүнд:

1. Сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө;
2. Аймаг, сум, нөхөрлөлийн ойн менежментийн төлөвлөгөө;
3. Аймгийн болон агнуурын бүс нутгийн агнуурын менежментийн төлөвлөгөө;
4. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө;
5. Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүс, Байгалийн нөөц газар; Дурсгалт газрын байгаль хамгааллын менежментийн төлөвлөгөө;
6. Бэлчээрийн менежментийн төлөвлөгөө зэрэг болно

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нар хуулиар оногдуулсан эдгээр үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн дагуу байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгээс бүрдүүлэх боломж бүрддэг.

Байгалийн нөөц баялгийг ашиглахдаа түүнийг хамгаалах, байгалийн жамаар нөхөн сэргэх боломжийг хангах арга хэмжээг авах ажлыг орхигдуулснаар тухайн нутаг дэвсгэрт байгаль орчны доройтол, нөөцийн хомсдол бий болж төсвийн тодорхой хэсгийг бүрдүүлдэг эх үүсвэр багасах нөхцөл үүсч болзошгүй юм. Ус гол ширгэх, амьтан дайжих, газрын үржил шим муудах, бэлчээрийн даац хэтрэх гэх мэт. Зарим аймаг суманд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг тухайн нөөцийг нэмэгдүүлэх арга хэмжээнд бараг зарцуулахгүй байна.

2. Амьтан ашигласнаас төсөвт ордог төлбөр хураамжийн мэдээлэл

Хүснэгт: 7

Засгийн газраас тусгай зориулалтаар гадаадын анчдад агнуулахаар тогтоосон амьтны тоо /2015 он/

Нэр	Угалз Алтайн	Угалз говийн	Тэх Алтайн	Тэх Говийн	Халиун буга	Бор гөрөөс	Зэрлэг гахай	Тул загас	Нийт үнэ /\$/
Төв		10			12				104040
Дорноговь		11							99000
Төв		10							90000
Говьсүмбэр		2							18000
Баян-Өлгий	8				3				147510
Завхан		2							18000
Хэнтий		1				10	10	80	27200
Дундговь		2							18000

Өвөрхангай		7		2				66520
Баянхонгор		3		15				53400
Увс	4							72000
Говь-Алтай			6					12000
Ховд			37					74000
Хөвсгөл							238	21420
Булган							22	1980
НИЙТ ДҮН								823070

### 3. Ургамал ашигласнаас төсөвт ордог төлбөр хураамжийн мэдээлэл

#### Хүснэгт 8

#### Байгалийн ховор ургамал түүж бэлтгэх зөвшөөрөл авахад тэмдэгтийн хураамжийн орлого

Бэлтгэсэн он	Ургамлын нэр	Хэмжээ	Тэмдэгтийн хураамж	Байгалийн нөөц ашигласны төлбөр /төг/
2012	Дэрэвгэр жиргэрүү	10 тонн	1 600 000	0
2013	Дэрэвгэр жиргэрүү	100 кг	400 000	0
2014	Дэрэвгэр жиргэрүү	59 тонн	218 744 000	177 000 000
2015	Дэрэвгэр жиргэрүү	75 тонн	300 000 000	207 000 000

Тайлбар: Байгалийн ховор ургамал түүж бэлтгэх зөвшөөрөл олгоход тэмдэгтийн хураамжинд 1 кг тутамд 4000 төгрөг төлнө гэж Улсын тэмдэгтийн хураамжийн хувь хэмжээг тогтоох тухай засгийн газрын 2011 оны 6 дугаар сарын 21-ны өдрийн 199 дүгээр тогтоолын 11.1.16-т заасан тул нэмэлт төлбөр авах боломжгүй байна.

#### Хүснэгт 9

#### Байгалийн ургамал, ойн дагалт баялаг тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг гадаадад гаргах зөвшөөрөл, тэмдэгтийн хураамжийн орлого

Гаргасан он	Ургамлын нэр	Хэмжээ	Тэмдэгтийн хураамж /төг/
2012	Хээрийн цагаан мөөг	600 кг	61 000
	Хоёр ишт бэриш	5 тонн	5 000 000
2013	Хээрийн цагаан мөөг	2100 кг	2 100 000
2014	Халгай	1000 кг	601 000
2015	Дэрэвгэр жиргэрүү	64 тонн 775 кг	191 625 000
	Хушны самрын идээ	474 тонн 520 кг	1 722 310 000

#### Байгалийн нөөцийн төлбөрийн нэгж үнэ, хэмжээг нэмэгдүүлэхэд хийгдэх ажлууд:

1. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн нэгжийн үнийг нэмэгдүүлэхэд Засгийн газрын 2001 оны 264 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулна.
2. Идлэг шонхорыг гадаад улсад гаргахыг хориглох тухай Засгийн газрын 2012 оны 15 дугаар тогтоолыг хүчингүй болгох.

3. Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын Байгалийн ургамлын экологи эдийн засгийн үнэлгээг тогтоосон тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах.
4. 2015 оны 11 дүгээр сарын 15-аас өмнө 2016 онд тусгай зориулалтаар агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээг Засгийн газрын хуралдаанд оруулж шийдвэрлүүлэх.
5. Байгалийн нөөцийн төлбөрийн орлогын тухай хуульд үйлдвэрийн зориулалтаар загас ашигласны үнийг нэмэгдүүлэх хуулийн төсөл боловсруулан УИХ-аар батлуулах.

*4.Химийн хорт болон аюултай бодисыг ашиглах, хадгалах, тээвэрлэхтэй холбоотой тусгай зөвшөөрөл*

НҮБ-аас 2003 онд “Химийн бодисын ангилал хаягжуулалтын нэгдсэн систем”-ийг батлан гаргасан бөгөөд Химийн аюулгүй байдлын тухай засгийн газар хоорондын форум, Тогтвортой хөгжлийн тухай дэлхийн дээд хэмжээний уулзалтаас уг ангиллыг 2008 он гэхэд дэлхий нийтээр дагаж мөрдөх зорилтыг тавьсан. Химийн хорт болон аюултай бодисыг ашиглах, хадгалах, тээвэрлэх үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөлийн тэмдэгтийн хураамж төлддөг.

*Хүснэгт: 10*

Химийн хорт болон аюултай бодисыг ашиглах, хадгалах, тээвэрлэхтэй холбоотой тусгай зөвшөөрлийн улсын тэмдэгтийн хураамж /төгрөгөөр/

Улсын тэмдэгтийн хураамж	2012 он	2013 он	2014 он	2015 он 9 сарынхаар	2016 он
	580,000,000	505,000,000	578,000,000	365,807,500	-

**4.Нөхөн сэргээлтийн барьцааны мөнгөн дүн**

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам”, “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А-04 дүгээр тушаалаар батлагдан хэрэгжиж байна.

Нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд 2014 оны 12 дугаар сарын 30-ны байдлаар 9.1 тэрбум төгрөгийг аж ахуйн нэгжүүд байршуулсан байна.

*Хүснэгт 11*

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны орлого /тэрбум төгрөгөөр/

	2008 он	2009 он	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он

Нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны орлого	1,19	1,58	2,52	3,74	5,75	7,30	9,1
---	------	------	------	------	------	------	-----

*Тайлбар: Монгол орны байгаль орчны төлөв байдлын тайлан 2013-2014 он*